

ӨМНӨХ ҮГ

2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр ШУА-ийн Их чуулганы танхимд зохион байгуулсан Монгол, Хятадын засгийн газрын түвшний анхны хамтын ажиллагааны баримт бичиг болох «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийн 70 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл Таны гарт хүрч байна.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс санаачлан Монгол, Хятад хоёр улсын төрийн холбогдох байгууллагууд, зарим төрийн бус байгууллагууд хамтран ажилласны үр дүнд энэхүү хурал амжилттай болж, эрдэмтэн судлаачдад 1952 оны хэлэлцээр, түүний хэрэгжилтийн түүхэн тойрон дахь үйл явцыг эргэн харж, эрдэм шинжилгээний дүгнэлтийг өнөөдрийн өндөрлөгөөс дахин нэг удаа хийх завшааныг олгосон юм.

1950-иад он бол Монгол, Хятадын харилцаа салбар салбарт өрнүүн хөгжсөн он жилүүд бөгөөд тэрхүү өрнүүн хөгжлийн суурь нь чухамдаа 1952 онд байгуулагдсан энэхүү хэлэлцээр байсан юм. Тийм ч учраас 1953, 1962 онд Монгол оронд уг хэлэлцээрийн 1 ба 10 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж байсан нь уг хэлэлцээр тухайн цагийн Монгол орны хөгжил дэвшилд ба Монгол, Хятадын харилцаанд ямархан ач холбогдолтой байсны гэрч тэмдэг болон үлджээ.

Хүйтэн дайн төгсөж, Монгол, Хятадын харилцаанд зарчмын өөрчлөлт орсон жилүүдэд уг хэлэлцээрийн хоёр улсын харилцааны түүхэнд эзлэх байр суурийг бүдгэрүүлж мэдэхүйц байдал зарим талаар цухалзах болсон нь холбогдох байгууллагуудаас эрхлэн гаргасан хоёр улсын харилцааны түүхийн чухал үйл явдлуудын жагсаалт, лавлахуудад энэхүү хэлэлцээрийг тэр болгон багтаахгүй, орхигдуулж байгаагаас харагдана. Цаг улирал яаж ч хувьссан, хоёр улсын харилцаа яаж ч өөрчлөгдсөн Монгол, Хятадын харилцааны тулгын чулуудын нэг тус хэлэлцээрийн түүхэн ач холбогдол гээгдэж ор тас мартагдахгүй нь мэдээж ч дээрх байдлыг бид хайхрахгүй байж бас болохгүй билээ. Иймийн тул, бид энэхүү эрдэм шинжилгээний хурлыг хэлэлцээрийн 70 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан юм. Энэ нь Монгол, Хятадын харилцаа 1990-ээд оноос шинэ цаг үед сэргэн хөгжсөнөөс хойших 30 илүү жилийн хугацаанд анх удаа тус хэлэлцээрийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн явдал болсон байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын харилцааны аливаа ойн хурал, тэр тусмаа хоёр талт харилцааны тэмдэглэлт ойн хүрээн дэх эрдэм шинжилгээний хурлуудын явц байдал ихэнхдээ илтгэгч ихтэй, хэлэлцүүлэг багатай байж бүхэлдээ магтан сайшаах хандлагаар хийгдэж байгаа нь илэрхий анзаарагдана. Бид энэхүү эрдэм шинжилгээний хурлаар энэ мэт хэв шинжээс аль болох зайлсхийж, цөөн илтгэгчтэй өргөн хэлэлцүүлэгтэй, академик чөлөөт байдлыг

эрхэмлэхийг зорилго болгож, зорилгоо ч биелүүлж чадсан хэмээн үзэж байна. Энэ бол уг хурлын чухал нэгэн онцлог болсон юм.

Энэхүү хэлэлцээр ба түүнийг байгуулсны үр дүнд хүрсэн өргөн далайцтай харилцаа, хамтын ажиллагааны ололт амжилтуудыг эргэн дурсахын зэрэгцээ алдаа эндлийг ч орхигдуулалгүй сөхөж, түүхэн сургамжийн үүднээс хэлэлцэж, асуудалд аль болох бодитой хандахыг хичээсэн нийт илтгэгчид ба хэлэлцүүлэгчдэдээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар болон «Нэг бүс, нэг зам» олон улсын хөгжлийн судалгааны академи ТББ, Дорно дахин судлалын хүрээлэн ТББ-ын удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлье.

Эрхэм уншигч Танаа түлхүү мэдээлэл хүргэх үүднээс илтгэлүүдтэй холбогдуулан панелистуудаас хэлсэн үгс ба хэлэлцүүлгийн үеэр өрнөсөн асуулт хариулт, санал сэтгэгдэл, шүүмжийг энэхүү эмхэтгэлд аль болохоор багтаахыг зорьж ажилласан гэдгийг дашрамд дуулгахад таатай байна.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн
Хятад судлалын салбарын эрхлэгч, доктор /Ph.D/
Дамдиндоржийн Базардорж